



“БЛЮСКАЙ СЕКҮЮРИТИЗ УЦК” ХУВЬЦААТ КОМПАНИИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Блюскай секьюритиз УЦК” ХК – ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 04 өдөр 13 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Жуулчны гудамж, Монгол Тайваны төвийн 2-р давхарт 207 тоот өрөөнд эхлэв.

Хуралд 1 гишүүн онлайнараар, 3 гишүүн саналын хуудсаар биечлэн оролцсон болно.

Хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Г.Оюунболд нээв.

ТҮЗ-ийн дарга Г.Оюунболд: ТҮЗ-ийн гишүүд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах, Компанийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах, Бусад зэрэг асуудлыг хэлэлцэнэ.

Гүйцэтгэх Захирал А.Арнунтуяа: 2021 оны 2 сарын 18-д хуралдсан Блюскай Секьюритиз УЦК ХК-ийн ТҮЗ-өөс компанийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангах, компанийн хүний нөөц боловсон хүчинийг бүрдүүлэх үүргийг компанийн гүйцэтгэх удирдлагад өгсөн.

Ингээд компаниас шинээр тусгай зөвшөөрөлтэй 2 брокеруудыг ажилд авч мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулав.

2021 онд компани өөрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангах зорилгоор нийт 780 сая төгрөгийн нэмэлт хувьцааг хаалттай хүрээнд гаргахаар төлөвлөж шаардлагатай хууль, үнэлгээ, аудитын дүгнэлтийг гаргуулж материалаа СЗХ, МХБ – д өгсөн.

2022 оны 3 сарын 9 өдрийн СЗХ-ын 100-р тогтоолоор компанийн хаалттай хүрээд гаргасан нэмэлт хувьцааг бүртгэхийг зөвшөөрөв.

Ингэснээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 780 сая төгрөгөөр нэмэгдэж өөрийн хөрөнгө 500 орчим сая төгрөгөөр нэмэгдэв.

Цаашид компани брокерын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан тул түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлөө сэргээх, шинээр хөрөнгө оруулалтын зөвлөх болон гадаад үнэт цаасны арилжаанд зуучлах тусгай зөвшөөрлийг нэмж авахаар төлөвлөж байна.

ТҮЗ-ийн дарга Г.Оюунболд: Компанийн брокерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл түдгэлзсэн байгаа. Үүнээс улбаалан ногдол ашиг хувиарлах хэмжээнд ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар ТҮЗ-өөс шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигчид: Дэмжиж байна.

ТҮЗ-ийн дарга Г.Оюунболд

Компани хөрөнгө оруулалтын зөвлөх болон гадаад хувьцаа арилжааны чиглэлээр цаашид ашигтай ажиллаж хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах шаардлагатай байна. Иймд үйл ажиллагааны чиглэлд дээрхтэй холбоотой тусгай зөвшөөрлүүдийг нэмж авах шаардлагатай байна.

Гүйцэтгэх Захирал А.Ариунтуяа : Мөн бусад гэх асуудлын хүрээнд их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх тухай юм. Компани нь цаашид Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрхийг нэмж авах гэж байгаатай холбогдуулан гадаад арилжааны платформ, Back office систем, IOS болон Android гар утасны аппликацийн шийдэлүүдийг хийх зайлшгүй шаардлагатай. Бид харилцагчдын арилжааны мэдээлэл, аюлгүй байдал, мөнгөн хөрөнгийг хамгаалах үүднээс маш сайн IT багаар найдвартай платформ хийлгүүлэх хэрэгтэй байна. Цаашид ч найдвартай IT баг нь хакераас хамгаалах, шинэчлэл хийж авч явах зайлшгүй шаардлагатай байгаа тул чадамжтай хувь хүн, хуулийн этгээдүүдийг шалгаруулан тэдэнтэй их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх саналтай байна. Одоогоор IT компанийн үнэ тодорхой биш байгаа ч хэрэгцээ шаардлагаар IT компанийн үнэ их өссөн байгаа тул энэхүү саналыг оруулж байна.

Хувьцаа эзэмшигчид: Дэмжиж байна. Яг зөв.

Ийнхүү ээлжит хурал 14 цаг 50 минутад дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: *Г.Оюунболд* Г.Оюунболд
Дөлгөөн

ХУРЛЫН ДАРГА: *Г.Оюунболд* Г.Оюунболд